



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2014 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Ногоон хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөтөлбөр батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны холбогдох шатны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Г.Баярсайхан - Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

А.Бакей - Улсын Их Хурлын гишүүн
Х.Болорчулуун - Улсын Их Хурлын гишүүн
С.Дэмбэрэл - Улсын Их Хурлын гишүүн
Я.Содбаатар - Улсын Их Хурлын гишүүн
Ц.Цолмон - Улсын Их Хурлын гишүүн
Л.Эрдэнэчимэг - Улсын Их Хурлын гишүүн

Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсэг:

Т.Булган - Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
Ж.Ганбат - Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга
Г.Батхүрэл - Эдийн засгийн хөгжлийн яамны Хөгжлийн бодлого, стратегийн төлөвлөлтийн газрын дарга
Б.Галбадрах - Зам, тээврийн яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын дарга
Л.Чой-Иш - Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Ц.Баярбат	-Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны газрын дарга
Д.Долгормаа	-Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
Г.Товуудорж	-Эрчим хүчний яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
Ч.Отгочулуу	-Уул уурхайн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
Б.Бадамцэцэг	-Үндэсний статистикийн хороо, Макро эдийн засгийн статистикийн газрын дарга
М.Төрбаяр	-Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Х.Хишигжаргал	-Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн
Г.Түмэнжаргал	-Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Цэвэр үйлдвэрлэл, цэвэр хөгжлийн газрын дарга
Д.Доржсүрэн	-“Цэнгэг усны хүрээлэн” ТББ-ын тэргүүн

2.Дээрх Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны холбогдох шатанд хэлэлцүүлэх бэлтгэлийг тухай бүр нь хангаж ажиллахыг Ажлын хэсэг /Г.Баярсайхан/-т даалгасугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Г.БАЯРСАЙХАН



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2014 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот


**Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2013 оны 04 дүгээр тогтоолоор байгуулсан Газрын багц хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны холбогдох шатанд хэлэлцүүлэх бэлтгэлийг хангаж, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Ц.Цолмонг нэмж оруулсугай.

2. Тогтоолын “Дэд ажлын хэсгийн ахлагч бөгөөд нарийн бичгийн дарга Д.Ганзориг” гэснийг “Дэд ажлын хэсгийн ахлагч бөгөөд нарийн бичгийн дарга Я.Хишигт” гэж өөрчилсүгэй.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Г.БАЯРСАЙХАН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2014 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

Төрөөс үйлдвэр, хөдөө, аж ахуйн талаар баримтлах бодлого түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон хөтөлбөр боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

М.Зоригт -Улсын Их Хурлын гишүүн

Гишүүдэд:

Г.Баярсайхан	-Улсын Их Хурлын гишүүн
Х.Болорчулуун	-Улсын Их Хурлын гишүүн
Д.Ганбат	-Улсын Их Хурлын гишүүн
Д.Дэмбэрэл	-Улсын Их Хурлын гишүүн
С.Дэмбэрэл	-Улсын Их Хурлын гишүүн
Ё.Отгонбаяр	-Улсын Их Хурлын гишүүн
С.Одонтуяа	-Улсын Их Хурлын гишүүн
Д.Сумъяабазар	-Улсын Их Хурлын гишүүн
Д.Эрдэнэбат	-Улсын Их Хурлын гишүүн
Ж.Эрдэнэбат	-Улсын Их Хурлын гишүүн

Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсэг:

Дарга:

Ц.Туваан -Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны дэд сайд

Нарийн бичгийн дарга:

Я.Хишигт -Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны зөвлөх

Гишүүдэд:

Х.Золжаргал -Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Л.Чой-Иш -Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Д.Энхмаа -Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны референт

Ч.Рэнчинсэнгээ	-Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
Б.Алтанцэцэг	-Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Хуулийн хэлтсийн дарга
С.Бэхбат	-Эдийн засгийн хөгжлийн яамны Инноваци төр-хувийн хэвшлийн газрын дарга
Б. Нямаа	-Сангийн яамны газрын дарга
Б.Баасандорж	-Хууль зүйн яамны Хууль эрх зүйн нэгдсэн бодлогын газрын дарга
Ц.Баярбат	-Барилга хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны газрын дарга
Д.Насанбаяр	-Боловсрол, шинжлэх ухааны яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
Б.Галбадрах	-Зам, тээврийн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
П.Алтан-Од	-Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
Б.Бат-Амгалан	-Хөдөлмөрийн яамны Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх газрын дарга
Н.Долгормаа	-Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
Г.Батхүрэл	-Эдийн засгийн хөгжлийн яамны Хөгжлийн бодлого, стратегийн төлөвлөлт, зохицуулалтын газрын дарга
П.Товуудорж	-Эрчим хүчний яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
Д.Мөнхбэт	-Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийн зохицуулалтын газрын дарга

Ажлын хэсгийн үйл ажиллагаанд холбогдох яам, газрын албан тушаалтныг тухай бүр татан ажиллуулж, хамтран ажиллаж байсугай.

Ажлын хэсгийн дүнг Байнгын хороонд 2013 оны намрын чуулганд багтаан танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /М.Зоригт /-д даалгасугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС ХӨДӨӨ
АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

 УХА0316

Г.БАЯРСАЙХАН



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2014 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

**Монгол орны ойн цэвэрлэгээний
талаар авах арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2013 оны 19 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгээс гаргасан дүгнэлт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

НЭГ. Монгол орны ойг цэвэрлэх талаар дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд /С.Оюун/-д үүрэг болгосугай. Үүнд:

1/ойн цэвэрлэгээ хийх шаардлагатай талбайн нарийвчилсан судалгаа хийж, түүнд тулгуурлан ойн цэвэрлэгээг экосистемд сөрөг нөлөөлөлгүйгээр ойн тогтвортой менежментийг ханган зохион байгуулж, ойжуулалт болон нөхөн сэргээх ажлыг төлөвлөн, хэрэгжүүлэх;

2/ойн цэвэрлэгээ хийхэд ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн болон төрийн бус байгууллагуудыг хамруулан төр, хувийн хэвшлийн оролцоог хангаж, шинээр ажлын байр бий болгох, шаардлагатай тохиолдолд ажилчдад мэргэжлийн ур чадвар олгох, дадлагажуулах сургалт зохион байгуулах;

3/ойн цэвэрлэгээнээс гарсан мод, модон бүтээгдэхүүн борлуулах, үртэс зоргодсоор шахмал түлш, барилгын материал үйлдвэрлэх санаачилгыг дэмжин зохион байгуулж, хэрэгжилтийг хангах талаар аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг, чиглэл өгч ажиллах;

4/ойн цэвэрлэгээ хийх газар нутгийн ойд замын хайгуул хийж, зураг, төсөв боловсруулах, ойн зам барьж байгуулах ажлын зардлыг жил бүрийн төсөвт тусгаж хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

5/мод, модон материалын зах зээлийн эрэлт хэрэгцээний тодорхой хэсгийг цэвэрлэгээнээс гарах бүтээгдэхүүнээр хангах замаар хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ авч ажиллах;

6/Монгол орны ойг цэвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор төсөл, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, мод орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа болон хаягдалгүй, ногоон технологи нэвтрүүлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжиж ажиллах.

ХОЁР.Энэ тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг холбогдох эх үүсвэрээс гаргаж дэмжлэг үзүүлэх, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллан, хэрэгжилтийн талаарх мэдээллийг 2014 оны намрын чуулганы хугацаанд Байнгын хороонд ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд /Н.Алтанхуяг/-д даалгасугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ
АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА


Г. БАЯРСАЙХАН

УХА0316



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2014 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Малын индексжүүлсэн даатгалын тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны холбогдох шатны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

А.Бакей -Улсын Их Хурлын гишүүн

Гишүүдэд:

Б.Гарамгайбаатар -Улсын Их Хурлын гишүүн
Д.Зоригт -Улсын Их Хурлын гишүүн
М.Зоригт -Улсын Их Хурлын гишүүн
Я.Содбаатар -Улсын Их Хурлын гишүүн
Ц.Цолмон -Улсын Их Хурлын гишүүн
Л.Энх-Амгалан -Улсын Их Хурлын гишүүн

Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсэг:

Ахлагч:

Я.Хишигт -Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны зөвлөх

Гишүүдэд:

С.Пүрэв -Сангийн дэд сайд
Б.Нямаа -Сангийн яамны Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Б.Бадамцэцэг -Үндэсний статистикийн хорооны Макро эдийн засгийн газрын дарга

Л.Чой-Иш	-Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
Н.Ганибал	-Үйлдвэр хөдөө аж ахуйн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
С.Ганболд	-Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын дарга
Б.Баасандорж	-Хууль зүйн яамны Хууль зүйн нэгдсэн бодлогын газрын дарга
Д.Намсрай	-Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас хамгаалах газрын дарга
П.Цэрэндэжид	-Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
Д.Эрдэнэбаяр	-Эдийн засгийн хөгжлийн яамны Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга
Б.Биньээ	-Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн
Я.Өлзийболд	-Малын индексжүүлсэн даатгал төслийн нэгжийн захирал

2.Ажлын дэд хэсгийн үйл ажиллагаанд холбогдох яам, газрын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулсугай.

3.Дээрх хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны холбогдох шатанд хэлэлцүүлэх бэлтгэлийг хангаж ажиллахыг Ажлын хэсэг /А.Бакей/-т даалгасугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС ХӨДӨӨ
АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА



Г.БАЯРСАЙХАН



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2014 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

**Ажлын хэсгийг шинэчлэн
байгуулах тухай**

Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэг, Байнгын хорооны 2014 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны санал хураалтын дүнг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Газрын тухай, Газрын төлбөрийн тухай, Газрын кадастрын тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төсөл, Геодези зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны холбогдох шатанд хэлэлцүүлэх бэлтгэлийг хангаж, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч :

Б.Гарамгайбаатар -Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

А.Бакей -Улсын Их Хурлын гишүүн
Су.Батболд -Улсын Их Хурлын гишүүн
Ж.Батсуурь -Улсын Их Хурлын гишүүн
Г.Баярсайхан -Улсын Их Хурлын гишүүн
С.Ганбаатар -Улсын Их Хурлын гишүүн
Ц.Цолмон -Улсын Их Хурлын гишүүн

Дэд ажлын хэсгийн ахлагч бөгөөд нарийн бичгийн дарга:

Я.Хишигт Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны зөвлөх


2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг хавсралтаар баталсугай

3.Дээрх төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны холбогдох шатанд хэлэлцүүлэх бэлтгэлийг тухай бүр нь хангаж ажиллахыг Ажлын хэсэг /Б.Гарамгайбаатар/-т даалгасугай

4.Ажлын хэсгийн үйл ажиллагаанд холбогдох байгууллага, албан тушаалтныг тухай бүр татан оролцуулж байхыг ажлын дэд хэсгийн ахлагч /Я.Хишигт/-д үүрэг болгосугай.

5.Байнгын хорооны 2013 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 04 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Г.БАЯРСАЙХАН

The image shows a red rectangular stamp with Mongolian text. The text inside the stamp is arranged in three vertical columns. The rightmost column contains the name 'Г.Баярсайхан' (G. Bayarsaikhan). The middle column contains the title 'Хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга' (Director of the Permanent Agricultural and Livestock Husbandry Agency). The leftmost column contains the name 'Байгаль Орчин, Хүнс' (Environment, Food). At the bottom of the stamp, there is a small number '916' and the letters 'УХХ' (Ukhkh). A black ink signature is written across the stamp, overlapping the text.

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс,
хөдөө аж ахуйн байнгын хорооны 2014
оны 06 дугаар тогтоолын хавсралт

**АЖЛЫН ХЭСЭГТ МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙН
ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ДЭД АЖЛЫН
ХЭСГИЙН ГИШҮҮД**

Г.Байгальмаа	Барилга, хот байгуулалтын дэд сайд
Э.Бат-үүл	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч
Л.Ням	Газрын шинэтгэлийн Үндэсний хорооны нарийн бичгийн дарга
С.Түмэнжаргал	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны референт /зөвшилцсөнөөр/
Д.Мөнхбаатар	Барилга, хот байгуулалтын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
Т.Булган	Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
Т.Эрдэнэчимэг	Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын дарга
Л.Чой-Иш	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын дарга
Б.Алтанцэцэг	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Хуулийн хэлтсийн дарга
Б.Баатарцогт	Уул уурхайн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Геологийн бодлогын хэлтсийн дарга
П.Золзаяа	Нийслэлийн шүүхийн Иргэний танхимын тэргүүн
Ц.Цогт	Захиргааны хэргийн давж заалдах шатны ерөнхий шүүгч
А.Хүрэлшагай	Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын дарга
Ж.Даваабаатар	Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын дэд дарга
В.Отгонбаяр	Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын Геодези зураг зүйн хэлтсийн дарга
Г.Баяржаргал	Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын Кадастрын хэлтсийн дарга
Р.Ганхуяг	Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын Газрын удирдлагын албаны дарга
Г.Цэцэгээ	Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бүртгэлийн газрын орлогч дарга

Э.Ариунгэрэл	Нийслэлийн өмчийн харилцааны газрын хуулийн хэлтсийн дарга
Б.Элбэгсайхан	Газрын шинэтгэлийн хорооны ажлын албаны ажилтан
Г.Нарантуяа	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын улсын ахлах байцаагч
Б.Золзаяа	Татварын ерөнхий газрын улсын байцаагч
О.Нямсүрэн	Хөдөө аж ахуйн их сургуулийн газар зүйн тэнхимийн багш
Х.Ыханбай	“Жасыл” холбооны тэргүүн
Л.Мөнх-Очир	Монголын хөрөнгийн үнэлгээчдийн институтын удирдах зөвлөлийн гишүүн



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

**Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх,
ойн нөхөн сэргээлтийг сайжруулах
талаар авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх, ойн нөхөн сэргээлтийн бодлого, үйл ажиллагааг сайжруулахтай холбогдуулан дараах арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т чиглэл болгосугай:

1/ойн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, ой хамгаалал, нөхөн сэргээлт, ойжуулалтын ажлыг урамшуулах санхүүгийн баталгаат эх үүсвэр бий болгох чиглэлээр холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар судалж, зохих арга хэмжээг авах;


2/ой сан бүхий газарт ой нөхөн сэргээх үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, ойн нөхөрлөлийн хаягдал мөчир, гишүү ашиглан эко бетон үйлдвэрлэх жижиг үйлдвэр байгуулах санаачилгыг дэмжиж, Жижиг дунд үйлдвэрийн сан, Зээлийн баталгааны сангаас дэмжлэг үзүүлэх бодлогыг хэрэгжүүлэх;

3/ойжуулах болон нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн байгууллагуудад техник, технологийн шинэчлэл хийх, хүчин чадлаа нэмэгдүүлэхэд зориулж удаан хугацаатай, хүү багатай зээл олгох, зээлийн хүүгийн хөнгөлөлт болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг судалж, холбогдох арга хэмжээг авах;

4/хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, урамшууллын арга механизмыг ашиглах, ойн нөөцийн орон нутаг дахь мэргэжлийн удирдлагын үүрэг бүхий ойн ангийн тоог хариуцах ойн талбайн хэмжээтэй нь уялдуулан нэмэгдүүлэх зэрэг иж бүрэн арга хэмжээ авах.

2.Энэ тогтоолоор өгсөн үүргийн биелэлтийг тус Байнгын хороонд 2018 оны эхний улиралд багтаан танилцуулсугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Г.БАЯРСАЙХАН



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2014 оны 5 сарын 14 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Ноос, ноолуурын салбарын бодлогын хэрэгжилтийн байдалтай танилцаж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Г.Баярсайхан -Улсын Их Хурлын гишүүн

Гишүүдэд:

А.Бакей -Улсын Их Хурлын гишүүн
Л.Болд -Улсын Их Хурлын гишүүн
Б.Гарамгайбаатар -Улсын Их Хурлын гишүүн
Я.Содбаатар -Улсын Их Хурлын гишүүн
Ц.Цолмон -Улсын Их Хурлын гишүүн
Л.Эрдэнэчимэг -Улсын Их Хурлын гишүүн

Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсэг:

Ахлагч:

Я.Хишигт -Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны зөвлөх

Гишүүдэд:

Ц.Баярмаа -ҮХААЯ-ны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
Б.Батцэцэг -ҮХААЯ-ны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн
Д.Гансэлэм -ЭЗХЯ-ны ХБСТЗГ-ын мэргэжилтэн
Г.Ёндонсамбуу -Монголын ноос, ноолуурын холбооны дэд тэргүүн
Д.Алтанцэцэг -Монголын ноос, ноолуурын холбооны гүйцэтгэх захирал
Д.Наранбаатар -“Говь” ХК-ийн дэд захирал

Б.Жаргалсайхан

-“Буян” ХХК-ийн захирал

П.Эрдэнэсайхан

-“Гоёо” ХХК-ийн дэд захирал

2.Ажлын дэд хэсгийн үйл ажиллагаанд холбогдох яам, газрын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулсугай.

3.Ноос, ноолуурын салбарын бодлогын хэрэгжилтийн байдалтай танилцсан ажлын дүнг Байнгын хороонд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Г.Баярсайхан/-д даалгасугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Г.БАЯРСАЙХАН



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2014 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 10/09

Улаанбаатар хот

Хамтарсан ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий хамтарсан ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Гарамгайбаатар -Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Г.Батхүү	-Улсын Их Хурлын гишүүн
Б.Бат-Эрдэнэ	-Улсын Их Хурлын гишүүн
Г.Баярсайхан	-Улсын Их Хурлын гишүүн
Х.Болорчулуун	-Улсын Их Хурлын гишүүн
Р.Бурмаа	-Улсын Их Хурлын гишүүн
Д.Дэмбэрэл	-Улсын Их Хурлын гишүүн
С.Дэмбэрэл	-Улсын Их Хурлын гишүүн
Д.Ганбат	-Улсын Их Хурлын гишүүн
Д.Зоригт	-Улсын Их Хурлын гишүүн
Ц.Нямдорж	-Улсын Их Хурлын гишүүн
Д.Оюунхорол	-Улсын Их Хурлын гишүүн
Г.Уянга	-Улсын Их хурлын гишүүн
Я.Содбаатар	-Улсын Их Хурлын гишүүн
Л.Цог	-Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, агентлаг, бусад байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, ажиллуулахыг Ажлын хэсэг /Б.Гарамгайбаатар/-т даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ГАРАМГАЙБААТАР

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.БАЯРСАЙХАН





**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2014 оны 5 сарын 21 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

**Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Улсын Их Хурал дахь Монгол Ардын Намын бүлгийн саналыг үндэслэн Байнгын хорооноос ТОГТООХ нь:

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2014 оны 06 дугаар тогтоолоор байгуулсан Газрын тухай, Газрын төлбөрийн тухай, Газрын кадастрын тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Геодези зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон дагалдах бусад хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны холбогдох шатанд хэлэлцүүлэх бэлтгэлийг хангаж, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийг чөлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаярыг ажлын хэсгийн гишүүнээр баталсугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Г.БАЯРСАЙХАН



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2014 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 18/М

Улаанбаатар хот

**Хамтарсан ажлын хэсэг
шинэчлэн байгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хороо, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий хамтарсан ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Гарамгайбаатар - Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Г.Баярсайхан	-Улсын Их Хурлын гишүүн
Д.Батцогт	-Улсын Их Хурлын гишүүн
Д.Ганбат	-Улсын Их Хурлын гишүүн
Д.Дэмбэрэл	-Улсын Их Хурлын гишүүн
С.Дэмбэрэл	-Улсын Их Хурлын гишүүн
Д.Зоригт	-Улсын Их Хурлын гишүүн
Я.Содбаатар	-Улсын Их Хурлын гишүүн
Г.Уянга	-Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, агентлаг, бусад байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, ажиллуулахыг Ажлын хэсэг /Б.Гарамгайбаатар/-т даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Эдийн засгийн байнгын хороо, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2014 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 10/09 тоот хамтарсан тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.ГАРАМГАЙБААТАР

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.БАЯРСАЙХАН